

ИХЭРМӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/20/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ...	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	15
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага.....	20
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/170
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой 109,475.8 мянган төгрөг, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, зохион байгуулалт, хөрөнгийн тооллоготой холбоотой 16,167.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, 35 дугаар зүйлийн 35.3, 41 дүгээр зүйлийн 41.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 заалтууд болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр зөрчил нь аудитаар тогтоосон материаллаг байдлын түвшнээс 49,134.5 мянган төгрөгөөр давж, дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2022 оны үйл ажиллагааны орлогын дүн өнгөрсөн оноос 2,020,289.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтнуудын хөдөө орон нутагт тогтвор, суурьшилтай ажилласны болон төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлын өсөлттэй холбоотой байна.

Байгууллагын төсвийн гүйцэтгэл 97.1 хувь буюу 5,260,532.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарч тайлант жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдэл 154,840.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Аудитын гол асуудал

БШУС-ын 2022 оны 2 сарын 22-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар аймгийн БШУГ-ын ажиллах үлгэрчилсэн журмыг баталж, байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орсон.

Тус байгууллага нь боловсрол, шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаа, төсвийн шинэчлэлийг орон нутагт зохион байгуулах, хянах, үнэлэх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн шинээр батлагдан гарсан журам, дүрмийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын даргын Хөвсгөл аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг төлөвлөж, 94.4 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А. ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ төгрөгөөр / Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,971,296.84	86,320,163.84
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	11,891,500.00
31210	Төгрөг	-	11,891,500.00
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	11,891,500.00
33	АВЛАГА	3,043,700.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,043,700.00	-
34	УРЬДЧИЛГАА	-	68,430,200.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	68,430,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,333,100.00	5,998,463.84
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	1,163,353.84
35400	Хангамжийн материал	1,333,100.00	4,835,110.00
35410	Бичиг хэргийн материал	260,000.00	1,846,790.00
35420	Аж ахуйн материал	430,000.00	2,246,620.00
35430	Сэлбэг хэрэгсэл	20,000.00	20,000.00
35470	Бусад хангамжийн материал	623,100.00	721,700.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	594,496.84	-
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	594,496.84	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,102,764,867.70	1,069,643,438.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,102,764,867.70	1,069,643,438.87
39200	Биет хөрөнгө	1,066,334,867.66	1,033,815,438.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	908,579,919.15	908,579,919.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	(41,747,281.92)	(55,663,042.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	107,600,000.00	107,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(38,699,999.99)	(58,466,666.77)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	132,604,747.68	167,966,650.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,092,125.51)	(68,224,822.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,458,383.74	67,403,383.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,580,653.49)	(45,591,861.14)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,400,000.00	5,400,000.00
39217	Ном	4,811,878.00	4,811,878.00
39300	Биет бус хөрөнгө	36,430,000.04	35,828,000.12
39301	Програм хангамж	6,267,000.00	6,267,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,086,999.96)	(4,688,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	34,250,000.00	34,250,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,107,736,164.54	1,155,963,602.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	11,874,900.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	11,874,900.00
41400	Урьдчилж орсон орлого	-	11,874,900.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	11,874,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,107,736,164.54	1,144,088,702.71
51	Засгийн газрын хувь оролцоо	1,107,736,164.54	1,144,088,702.71
51100	Засгийн газрын оруулсан капитал	185,365,274.48	185,365,274.48
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	185,365,274.48	185,365,274.48
51200	Хуримтлагдсан үр дүн	833,379,431.87	869,731,970.04
51210	Өмнөх үеийн үр дүн	731,834,679.64	833,379,431.87
51220	Тайлант үеийн үр дүн	101,544,752.23	36,352,538.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	88,991,458.19	88,991,458.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,107,736,164.54	1,155,963,602.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,926,991,398.57	5,885,822,061.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	338,937,836.75	277,479,261.00
120	Нийтлэг татварын бус орлого	338,937,836.75	277,479,261.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	121,523,926.88	43,306,903.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	217,413,909.87	234,172,358.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,588,053,561.82	5,608,342,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,223,178,600.00	5,415,373,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,223,178,600.00	5,415,373,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	364,874,961.82	192,969,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,086,400.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,018,000.00	58,627,680.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	337,270,561.82	134,325,120.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,500,000.00	16,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,825,446,646.34	5,849,469,522.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,825,446,646.34	5,849,469,522.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	975,857,890.14	887,596,796.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	279,990,889.30	331,292,773.94
210101	Үндсэн цалин	199,522,568.12	219,807,265.11
210102	Нэмэгдэл	55,873,921.16	46,823,254.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,729,646.02	34,617,696.00
210104	Урамшуулал	11,864,754.00	30,044,558.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,634,487.72	42,161,245.92
210201	Тэтгэврийн даатгал	25,365,820.06	28,780,492.70
210202	Тэтгэмжийн даатгал	2,820,908.89	3,385,495.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,253,366.96	2,678,157.13
210204	Ажилгүйдлийн даатгал	560,970.76	658,232.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,633,421.05	6,658,867.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,956,834.37	38,287,243.87
210301	Гэрэл, цахилгаан	1,584,672.45	1,857,869.62
210302	Түлш, халаалт	33,804,323.24	33,804,322.20
210303	Цэвэр, бохир ус	1,567,838.68	2,625,052.05
2104	Хангамж, бараа материалын зардал	266,087,754.45	15,305,129.40
210401	Бичиг хэрэг	16,529,641.82	1,946,260.00
210402	Тээвэр, шатахуун	3,770,890.00	8,547,037.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	974,039.60	991,142.20
210404	Ном, хэвлэл	100,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	26,826,700.00	64,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,898,070.00	3,756,240.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	214,988,413.03	-
2105	Нормативт зардал	3,633,600.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,633,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	165,130.00	3,421,500.00

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар		
2107	Томилолт, зочны зардал	165,130.00	3,421,500.00
210702	Дотоод албан томилолт	54,000.00	3,629,000.00
		54,000.00	3,629,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	279,403,431.00	9,171,961.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	279,403,431.00	9,171,961.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,931,763.30	444,327,942.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,328,200.00	250,154,151.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,113,500.00	117,745,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,490,063.30	76,428,331.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,849,588,756.20	4,961,872,725.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,780,407,693.40	4,805,222,977.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,397,860,603.40	1,759,287,023.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,363,719,090.00	3,029,445,954.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,828,000.00	16,490,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	69,181,062.80	154,840,713.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,181,062.80	154,840,713.27
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,809,035.60
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,809,035.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	101,544,752.23	36,352,538.17
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	101,544,752.23	36,352,538.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,588,053,561.82	5,623,261,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,588,053,561.82	5,623,261,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,223,178,600.00	5,415,373,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,223,178,600.00	5,415,373,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	364,874,961.82	207,888,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,086,400.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,018,000.00	58,627,680.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	337,270,561.82	146,200,020.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,500,000.00	3,060,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,564,353,561.82	5,611,369,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,564,353,561.82	5,611,369,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	711,721,105.62	649,497,174.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,391,500.81	331,292,773.94
210101	Үндсэн цалин	205,488,712.79	219,807,265.11
210102	Нэмэгдэл	54,566,803.00	46,823,254.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,471,231.02	34,617,696.00
210104	Урамшуулал	11,864,754.00	30,044,558.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,634,488.00	42,161,245.92

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал		
210202	Тэтгэмжийн даатгал	25,365,816.82	28,780,492.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,820,908.89	3,385,495.89
210204	Ажилгүйдлийн даатгал	2,253,367.06	2,678,157.13
210205	Эрүүл мэндийн даатгал	560,970.93	658,232.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,633,424.30	6,658,867.98
210301	Гэрэл, цахилгаан		
210302	Түлш, халаалт	1,709,452.47	1,857,869.62
210303	Цэвэр, бохир ус	33,804,323.24	33,804,322.20
2104	Хангамж, бараа материалын зардал	1,567,838.68	2,625,052.05
210401	Бичиг хэрэг	49,023,841.42	13,247,761.00
210402	Тээвэр, шатахуун	16,459,641.82	2,139,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,770,890.00	6,537,908.80
210404	Ном, хэвлэл	974,039.60	991,142.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,826,700.00	64,450.00
2105	Нормативт зардал	892,570.00	3,515,210.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,633,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,633,600.00	-
210604	Урсгал засвар	165,130.00	3,385,700.00
2107	Томилолт, зочны зардал	165,130.00	3,385,700.00
210702	Дотоод албан томилолт	54,000.00	3,629,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,000.00	3,629,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	279,403,431.00	9,171,961.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	279,403,431.00	9,171,961.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,333,500.00	208,321,488.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	220,000.00	20,444,470.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,113,500.00	187,877,018.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,852,632,456.20	4,961,872,725.87
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,780,407,693.40	4,805,222,977.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,397,860,603.40	1,759,287,023.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,363,719,090.00	3,029,445,954.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,828,000.00	16,490,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,224,762.80	154,840,713.27
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	69,181,062.80	154,840,713.27
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,043,700.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,809,035.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	1,809,035.60
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	23,700,000.00	11,891,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,700,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	23,700,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,700,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(23,700,000.00)	-

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	11,891,500.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	11,891,500.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	185,365,274.48	91,223,882.19	729,602,255.64	1,006,191,412.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,232,424.00	2,232,424.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	185,365,274.48	91,223,882.19	731,834,679.64	1,008,423,836.31
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(2,232,424.00)	-	(2,232,424.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	101,544,752.23	101,544,752.23
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	185,365,274.48	88,991,458.19	833,379,431.87	1,107,736,164.54
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	185,365,274.48	88,991,458.19	833,379,431.87	1,107,736,164.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	36,352,538.17	36,352,538.17
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	185,365,274.48	88,991,458.19	869,731,970.04	1,144,088,702.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр / Зөрүү Хувь	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,415,373,400.00	5,260,532,686.73	154,840,713.27	97.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,415,373,400.00	5,260,532,686.73	154,840,713.27	97.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,547,600.00	470,949,709.73	72,597,890.27	86.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	372,815,400.00	331,292,773.94	41,522,626.06	88.9
210101	Үндсэн цалин	227,574,800.00	219,807,265.11	7,767,534.89	96.6
210102	Нэмэгдэл	74,563,100.00	46,823,254.55	27,739,845.45	62.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,396,000.00	34,617,696.00	(1,221,696.00)	103.7
210104	Урамшуулал	37,281,500.00	30,044,558.28	7,236,941.72	80.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,601,900.00	42,161,245.92	4,440,654.08	90.5
210201	Тэтгэврийн даатгал	31,689,300.00	28,780,492.70	2,908,807.30	90.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,728,200.00	3,385,495.89	342,704.11	90.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,982,500.00	2,678,157.13	304,342.87	89.8
210204	Ажилгүйдлийн даатгал	745,600.00	658,232.22	87,367.78	88.3

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	7,456,300.00	6,658,867.98	797,432.02	89.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,849,500.00	38,287,243.87	562,256.13	98.6
210301	Гэрэл, цахилгаан	3,565,500.00	1,857,869.62	1,707,630.38	52.1
210302	Түлш, халаалт	32,583,200.00	33,804,322.20	(1,221,122.20)	103.7
210303	Цэвэр, бохир ус	2,700,800.00	2,625,052.05	75,747.95	97.2
2104	Хангамж, бараа материалын зардал	13,182,300.00	11,747,811.00	1,434,489.00	89.1
210401	Бичиг хэрэг	2,302,300.00	2,139,050.00	163,250.00	92.9
210402	Тээвэр, шатахуун	5,120,500.00	5,037,958.80	82,541.20	98.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,188,800.00	991,142.20	197,657.80	83.4
210404	Ном, хэвлэл	165,300.00	-	165,300.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	881,200.00	64,450.00	816,750.00	7.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,524,200.00	3,515,210.00	8,990.00	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,385,700.00	3,385,700.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,385,700.00	3,385,700.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,946,800.00	3,629,000.00	317,800.00	91.9
210702	Дотоод албан томилолт	3,946,800.00	3,629,000.00	317,800.00	91.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,924,100.00	9,171,961.00	23,752,139.00	27.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,924,100.00	9,171,961.00	23,752,139.00	27.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,841,900.00	31,273,974.00	567,926.00	98.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,996,800.00	11,993,970.00	2,830.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,845,100.00	19,280,004.00	565,096.00	97.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,871,825,800.00	4,789,582,977.00	82,242,823.00	98.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,871,825,800.00	4,789,582,977.00	82,242,823.00	98.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,771,245,300.00	1,759,287,023.00	11,958,277.00	99.3
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,099,730,500.00	3,029,445,954.00	70,284,546.00	97.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	850,000.00	850,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,415,373,400.00	5,260,532,686.73	154,840,713.27	97.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,415,373,400.00	5,260,532,686.73	154,840,713.27	97.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,415,373,400.00	5,260,532,686.73	154,840,713.27	97.1

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	25.00	(3.00)	113.6
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	16.00	5.00	76.2
620003	Үйлчлэх ажилтан		8.00	(8.00)	

Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Код	Үзүүлэлт			/ төгрөгөөр /	
				Дүн	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН			195,996,500.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ			195,996,500.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ			178,547,464.40	
2104	Хангамж, бараа материалын зардал			1,499,950.00	
210402	Тээвэр, шатахуун			1,499,950.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал			177,047,514.40	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			8,450,500.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			168,597,014.40	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			15,640,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг			15,640,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			15,640,000.00	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг			1,809,035.60	
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт			1,809,035.60	
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			207,888,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			207,888,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			58,627,680.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			146,200,020.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого			3,060,300.00	
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			11,891,500.00	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			11,891,500.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь:

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан ажлын хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;
- Боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем (багш, ажилтан, суралцагч, боловсролын сургалтын байгууллага, түүний орчны мэдээллийн бүртгэл бүхий)-ийг бүрдүүлж, хөгжүүлэхэд цэцэрлэг, сургууль, техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах;
- Боловсролын сургалтын байгууллагын мэдээлэл, холбооны дэд бүтэц, сүлжээний төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, утасгүй дотоод сүлжээний болон цахим сургалтын орчныг бүрдүүлэх, тогтвортой байдлыг хангах, хүний нөөцийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх;
- Боловсрол, шинжлэх ухааны байгууллагын ажилтан авлига авах, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх;
- Орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны байгууллагын гадаад хамтын ажиллагааг

өргөжүүлэх, хууль тогтоомжид нийцсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагыг гадаадын ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг БШУЯ-ны харьяа байгууллага юм.

Байгууллагын даргын Хөвсгөл аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг төлөвлөж, 94.4 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу 2022 оны 12 сарын 26-ны өдөр байгууллагын дотоод хяналтын багийг шинэчлэн байгуулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд байгууллагын дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн БШУГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн БШУГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,227.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3
Мөнгөн хөрөнгө	-	11,891.5	11,891.5
Авлага	3043.7	-	-3,043.7
Урьдчилгаа	-	68,430.2	68,430.2
Бараа материал	1333.1	5,998.5	4,665.4
Үндсэн хөрөнгө	1102764.9	1,069,643.4	-33,121.4
Бусад эргэлтийн хөрөнгө	594.5	-	-594.5
Нийт хөрөнгө	1,107,736.2	1,155,963.6	48,227.4
Богино хугацаат өр төлбөр	-	11,874.9	11,874.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,107,736.2	1,144,088.7	36,352.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө / өмчийн дүн	1,107,736.2	1,155,963.6	48,227.4

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, бараа материал, богино хугацаат өр төлбөр, эздийн өмч дандууд өмнөх оноос нэмэгдэж, авлага, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд ХААН банк өөрийн түр дансаар төсөвт байгууллагуудын гүйлгээг дамжуулахгүй болсонтой холбоотойгоор боловсролын байгууллагын ажилтнуудад хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан болон төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг олгох зориулалтаар 2022 оны 8 дугаар сард нээсэн дансанд жилийн эцэст данс андуурсан мөнгө орсноос шалтгаалан арилжааны банкны харилцах данс 11,891.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.
2. Улсын төсөвт 2021 оны жилийн эцэст төвлөрүүлсэн нэмэлт төсвийн дансны үлдэгдэл 3,043.7 мянган төгрөгийг буцаан авч, авлага дансны үлдэгдэл буурсан байна.
3. Төсвийн жил дамжин хэрэгжих сургалтуудын төлбөрийг 2022 оны 12 дугаар сард урьдчилан шилжүүлснээс урьдчилгаа дансны үлдэгдэл 68,430.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.
4. Бараа материал дансны үлдэгдэл 4,665.4 мянган төгрөгөөр нэмэгдэхэд бэлэн бүтээгдэхүүн, бичиг хэргийн материал, аж ахуйн материал дансны үлдэгдэл нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
5. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 33,121.4 мянган төгрөгөөр буурахад тайлант үеийн элэгдлийн зардал гол нөлөөг үзүүлсэн байна.
6. “Хөвсгөл судлал-2022” эрдэм шинжилгээний хурлын илтгэлийг эмхэтгэн гаргах зориулалттай, гүйцэтгэл нь төсвийн жил дамжин хэрэгжих 11,874.9 мянган төгрөгийг арилжааны банкны харилцах дансаар хүлээн авч урьдчилж орсон орлогоор бүртгэсэн нь богино хугацаат өр төлбөр данс нэмэгдэх шалтгаан болсон байна.

7. Засгийн газрын хувь оролцоо данс 36,352.5 мянган төгрөгөөр нэмэгдэхэд тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих урсгал зардлын дүнг 520,058.1 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 134,378.8 мянган төгрөгөөр бууруулан, 385,679.3 мянган төгрөгөөр, Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтнуудад олгох тэтгэмжийн зардал 4,866,805.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 5,252,484.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур төсөвт тодотголоор 162,888.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь 5,415,373.4 мянган төгрөг болсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 5,415,373.4 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс хүлээн авч, жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 154,840.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, төсвийн гүйцэтгэл 97.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн ажилтнуудад олгох орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлын гүйцэтгэл 96.1-99.0 хувийн гүйцэтгэлтэй, байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал 87.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан бол байр ашиглалтын үйлчилгээний зардал гүйцэтгэл гараагүй байна.

Үндсэн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд цалингийн зардал 88.9 хувийн гүйцэтгэлтэй буюу 41,522.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 90.5 хувийн гүйцэтгэлтэй буюу 4,440.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 27.9 хувийн гүйцэтгэлтэй буюу 23,752.1 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан нь төсвийн гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

Хангамж бараа материалын зардлын гүйцэтгэл 89.1 хувийн гүйцэтгэлтэй, 1,434.5 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр	Арга хэмжээ, зориулалт	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
				Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801-сургуулийн өмнөх боловсрол	80802-ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшил	1,136,305.1	1,091,946.3	44,358.8	96.1
2	71802-Ерөнхий боловсролын сургууль	80802-ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшил	3,734,670.7	3,696,786.6	37,884.1	99.0
3	71808-Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	526,731.3	462,455.7	64,275.6	87.8
4	71808-Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	8,494.4	8,494.0	0.4	100.0
5	71808-Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	8,321.9	0.0	8,321.9	0.0

6	71808-Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	80802-ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшил	850.0	850.0	0.0	100.0
Дүн			5,415,373.4	5,260,532.7	154,840.7	97.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт төсвийн дансаар 195,996.5 мянган төгрөгийг хүлээн авч, зарцуулсан байна. Үүнд:

Хөвсгөл аймгийн Засаг дарга	34,123.5	мянган төгрөг
Хөвсгөл аймгийн ЗДТГ	3,500.0	мянган төгрөг
Хөвсгөл аймгийн ОНХС	18,848.0	мянган төгрөг
Боловсролын чанарын шинэчлэл төсөл	5,623.4	мянган төгрөг
БШУЯ	5,761.0	мянган төгрөг
Боловсролын үнэлгээний төв	4,450.5	мянган төгрөг
Боловсролын ерөнхий газар	116,846.4	мянган төгрөг
Сангийн яам	3,043.7	мянган төгрөг
Тогтвортой ноос ноолуурын эвсэл	3,800.0	мянган төгрөг

Төсвийн жилийн эцэст нэмэлт төсвийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 1,809.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллагад 2022 онд 162,089.3 мянган төгрөгийн 13 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр дээд шатны байгууллагаас нэмэлт төсвийн дансанд санхүүжилтийг хүлээж авсан ба 160,203.6 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч, 98.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвлөн туслах, хяналт-шинжилгээ хийх	2022	Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд зөвлөн туслах, хяналт шинжилгээ хийх арга барилд боловсролын байгууллагууд суралцсан байна.	99.7	5,623.4	5,607.0
2	Жаргалант сумын сурагчдын сургалтын хоцрогдол арилгах сургалтын үйл ажиллагааны зардал	2022	Жаргалант сумын ЕБС-н багш нарт цар тахлын үеийн сэтгэц, нийгэмшихүйн хөгжлийн хоцрогдлыг арилгах 4 цагийн лекц, Хүүхдийн хөгжил төлөвшилтөд туслах нь эцэг эхийн хүлээсэн үүрэг сэдвээр 6 цагийн лекц, ярилцлага зохион байгуулах, сургуулийн сурагчдад сэтгэл зүйн ганцаарчилсан	100.0	4,961.0	4,961.0

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			зөвлөгөө өгөх /5 цаг/ үйл ажиллагаанууд явагдсан байна.			
3	Шинэ зууны малчин хөтөлбөр	2022	Хичээлээс гадуурх сургалтын нийт 180 хүүхдэд 35 цагийн хичээлээс 119 цагийн хичээл зааснаар, мал аж ахуйн үр өгөөж түүний онцлогыг судлан суралцсан байна.	100.0	3,800.0	3,800.0
4	Тоглонгоо суралцъя хөтөлбөр	2022	Багш нар сургалтыг тоглоомын аргаар зохион байгуулах арга зүйл суралцсан байна.	95.9	21,000.0	20,136.4
5	"Хөгжлийг бүтээгч Хөвсгөл" шинжлэх ухааны хэрэглээний шинэ санаа, шилдэг бүтээл шалгаруулах ажлын санхүүжилт	2022	ЕБС-н багш, сурагчдын хүрээнд шинэ бүтээл ашигтай загвар бий болгох боломж бүрдүүлэх, мэдлэгээ шинжлэх ухаанчаар ашиглах чадвар хөгжүүлэх, хамтран ажиллах арга барилд суралцана.	100.0	7,900.0	7,900.0
6	Англи хэлний багш нар суралцахуйг дэмжих арга хэмжээ	2022	Англи хэлний багш нар суралцахуйг дэмжих арга хэмжээний хүрээнд мэдлэг мэргэжлийн түвшин өссөн байна.	96.1	8,954.0	8,602.0
7	АЗДаргын 2022 оны А/391 дүгээр захирамжаар "Хөвсгөл судлал-2022" эрдэм шинжилгээний хурлын зардал	2022	Шинэ санаа , бүтээл бий болох зорилгоор "Хөвсгөл судлал-2022" эрдэм шинжилгээний хурлыг чанартай зохион байгуулсан байна.	100.0	7,232.5	7,232.5
8	Залуу багш нар-сайн хичээл	2022	Залуу багш нарт ёс зүй, үнэт зүйлийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, багшийн суурь ур чадварууд дээшилж харилцаан хандлага, хариуцлага, ухамсарт зэрэг өөрчлөлт бий болсон байна. /1-5 дахь жилдээ ажиллаж буй 500 залуу багш/	100.0	12,000.0	12,000.0
9	Боловсролын системд цахим систем нэвтрүүлж, цахим сургалт, үнэлгээний арга зүй технологийг хөгжүүлэх	2022	Мэдээлэл харилцааны технологид суурилсан ЭЕШ-н бодлого, менежмент арга зүй бий болно. Хөвсгөл аймгийн ЭЕШ -н амжилт ахисан байна. Мөн сурагчдын бие даан суралцах арга барил дээшилсэн байна.	97.1	10,948.0	10,630.0
10	Унших ба тоо бодох чадварыг хөгжүүлэх арга зүйг хэрэгжүүлэх	2022	ЕБС-н сурагчдын тоо бодох унших чадварыг нэмэгдүүлэх арга барил төлөвшсөн байна.	97.0	11,240.2	10,904.5
11	Математикийн багш нарт хийх цахим сургалтын төлбөр	2023	Хөвсгөл аймгийн 160-н математикийн багш цахим сургалтын талаар зэрэг хандлагатай , бие даан суралцах арга барилтай болсон байна.	0.0	6,400.0	6,400.0
12	Физикийн олимпиадын зохион байгуулах зардал	2023	Ази тивийн 23 дахь удаагийн физикийн олимпиадын бэлтгэл сургалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулж үр дүн гаргасан байна	0.0	13,439.0	13,439.0
13	Шинэ эгэл арга зүй	2023	ЕБС-н сурагчдын математик, физикийн хичээлд сургалтын хоцрогдлыг арилгах туршилтын сургалт хөтөлбөр удирдамжийн дагуу үр дүн гарсан байна.	0.0	48,591.2	48,591.2
Дүн				98.8	162,089.3	160,203.6

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн БШУГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Б.Мядагмаа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн БШУГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 38 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,825,446.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 76,508.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардалд 1,996.7 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Энэ хуулийн хүрээнд төсвийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 30 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 заалтад заасан Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулах заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 заалтад заасан албан томилолт давхардуулан олгохтой холбоотой заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3 заалтад заасан хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглосон заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй асуудалд зөвлөмж хүргүүлсэн ба тайлангийн 4.4.1 хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

Байгууллагын ажилтнуудад Улаанбаатар хот, өөр аймагт ажилласан албан томилолтыг давхардуулан олгосон 917.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тавьсан ба ажилтны докторын сургалтын төлбөрт 1,600.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон зөрчилд зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн БШУГ-ын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 5 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй, тайлант хугацаанд мэдээлэх 146 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

Мэдээллийн агуулга, үнэн зөв байдлыг шалгахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 795,939.1 мянган төгрөгийн 20 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, 1,955,343.8 мянган төгрөгийн 13 мэдээлэл мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “чалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 заалтад заасан хугацаанд жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулаагүй, нярвын тайланг сар бүр бэлтгэдэггүй, үлдэгдлийг нягтлан бодогч тулган баталгаажуулаагүй, жолоочийн тооцоо бодоогүй, байгууллагын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлийг үр дүнтэй зохион байгуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1¹, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6² дахь заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалт, хөрөнгийн тооллоготой холбоотой гаргасан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн БШУГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар 6,568.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 2 төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэснийг байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн боловч жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хянаж үзэхэд биелүүлээгүй байсан тул тайлант оны буруу илэрхийлэлд оруулсан болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилчдад олгосон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны болон төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зарцуулалт,

¹ Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ
² Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалт, дотоод хяналтыг сайжруулсан эсэх, БШУС-ын 2022 оны А/125 дугаар тушаалаар батлагдсан жишигт нийцүүлж орон тоог аймгийн Засаг даргаар батлуулсан эсэх, түрээсийн сурах бичгийг хүлээн авч орлогод авах, сургуулиудад түгээх, ашиглалт, түрээсийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих чиг үүргийн хэрэгжилт зэргийг анхаарч үзэх нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,204,572.5 мянган төгрөгийн 29 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 327,646.2 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсвийн зарцуулалттай холбоотой 20,653.2 мянган төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 104,990.2 мянган төгрөгийн 8 зөрчилд албан шаардлагыг хүргүүлж, 3 зөвлөмжийг өгсөн. Нийцлийн аудиттай холбоотой 2,751,282.9 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 327,646.2 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулгыг хийсэн болно. Үүнд:

- Дараагийн төсвийн жил дамжин хэрэгжих 68,430.2 мянган төгрөгийн 3 арга хэмжээг аккруэл сууриар бүртгээгүй, тайлант үеийн зардлаар бүртгэсэн байсныг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн.
- Аж ахуйн нэгжээс өгсөн 4,411.0 мянган төгрөгийн хандивын орлогыг дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй хүлээж авсан хөрөнгийн хамт хүлээн зөвшөөрч бүртгэсэн байсныг хандив, тусламжийн орлогоор залруулсан.
- Бусад эргэлтийн хөрөнгө дансанд эргэлтийн хөрөнгөнд хамаарах 594.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байсныг бараа материал дансанд залруулсан.
- БШУЯ-аас ирсэн 232,990.7 мянган төгрөгийн сурах бичгийг орлогод аваагүй, сургуулиудад олгосон зарлагыг бүртгээгүй орхигдуулсан байсныг бүртгэлд тусгаж залруулсан.
- Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан болон тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжийн 21,219.8 мянган төгрөгийн гүйлгээг хөтөлбөр, зориулалтыг хооронд шилжүүлэн зарцуулсныг зөв хөтөлбөр, арга хэмжээнд залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар илэрсэн дараах 20,653.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

- Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн багш Жавзандуламд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 4,498.4 мянган төгрөгийг давхардуулан олгосон, төрийн албанд ажилласан жилийг илүү тооцоолон 3 багш, ажилтанд 5,461.3 мянган төгрөгийн тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх.”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах,” заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- БШУГ-ын дарга Ц.Ганзориг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2,070.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 заалтыг зөрчиж, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Ажил гүйлгээ гарсныг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу 6,960.0 мянган төгрөгийн томилолтыг байгууллагын ажилтнуудад олгосон, Улаанбаатар, бусад аймагт ажилласан томилолтын зардлыг үйл ажиллагаа зохион байгуулсан байгууллагын зүгээс санхүүжүүлсэн байхад 917.6 мянган төгрөгийн томилолтыг давхардуулан олгосон, томилолтоор ажилласан хугацаанд 745.5 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг 17 ажилтанд давхардуулан олгосон нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх.”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 “Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.” заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсвийн гүйцэтгэл, хөрөнгийн тооллого, нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалт, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 104,990.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлантай аудиттай холбоотой дараах зөрчилд зөрчил таслан зогсоох, дахин давтахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн.

- Төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжийг авах шалгуур хангаагүй, нас барсан багш, ажилтанд 71,107.8 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх.”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн дансаар дамжуулан 4,200.0 мянган төгрөгийн төлбөр гүйцэтгэсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1 “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” заалтыг зөрчиж, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Байгууллагын албан хаагчийн докторын сургалтын төлбөр 1,600.0 мянган төгрөгийг төсвөөс төлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 “хуулиар зөвшөөрөөгүй бусад.” заалтыг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны маягт үйлдэхгүйгээр 13,206.5 мянган төгрөгийн шатахууныг олгосон, сургалтад оролцсон багш нарт зорчигчийн тийзгүйгээр 2,691.0 мянган төгрөгийн замын зардал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ХААН банканд зөвшөөрөлгүй данс нээж 11,874.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ.” заалтыг зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн

дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нярвын тайланг сар бүр бэлтгэдэггүй, үлдэгдлийг нягтлан бодогч тулган баталгаажуулдаггүй, жолоочийн тооцоо бодоогүй, байгууллагын дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” Заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж болон төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас нийт 82,242.8 мянган төгрөгийг зарцуулаагүй улсын төсөвт төвлөрүүлсний дотор тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмж авахаар төсөв батлагдсан багш, ажилчид бүгд тэтгэмжээ авч, үлдсэн мөнгөнөөс төсөвт мөнгө нь батлагдаагүй багш ажилчдад тэтгэмжийг олгож, 11,958.3 мянган төгрөгийг зарцуулаагүй буцааж төвлөрүүлсэн нь төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй хийх шаардлагатай болохыг харуулж байна. Энэ зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах

2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Ажиллагсдад олгох хоолны хөнгөлөлтийг 2022 оны нэгдүгээр сард олгоогүй, 12 дугаар сард 20.0 мянган төгрөгөөр, бусад сард 5.5 мянган төгрөгөөр тооцон олгосон, нэг өдөрт олгох хоолны хөнгөлөлтийн дүнг тогтоосон шийдвэр гаргаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажиллагсдад нэг өдөрт хоолны хөнгөлөлтийг жилийн эхэнд батлагдсан төсөвтөө багтаан тогтоож, шийдвэр гаргаж байх.

3. Орон тоо бүтэцтэй холбоотой асуудал.

Илрүүлэлт : БШУС-ын 2022 оны А/125 дугаар тушаалаар батлагдсан жишигт нийцүүлж орон тоог аймгийн Засаг даргаар батлуулаагүй, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны А/389 захирамжаар баталсан орон тоонд заагаагүй орон тоон дээр ажилтан томилон ажиллуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх.”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” зарчмыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: БШУС-ын тушаалаар батлагдсан жишигт нийцүүлэн байгууллагын орон тоог аймгийн Засаг даргаар батлуулах

4. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт : Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 5 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй, тайлант хугацаанд мэдээлэх 146 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

Мэдээллийн агуулга, үнэн зөв байдлыг шалгахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 795,939.1 мянган төгрөгийн 20 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн,

1,955,343.8 мянган төгрөгийн 13 мэдээлэл мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг мөрдөж, мэдээллийг тухай бүр байршуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дараагийн жил дамжин хэрэгжих арга хэмжээг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн	3	68,430.2			3	68,430.2	3	68,430.2
Хандиваар авсан хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн.	1	4,411.00			1	4,411.00	1	4,411.00
Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн	1	594.5			1	594.5	1	594.5
Яамнаас ирсэн түрээсийн сурах бичгийг орлогод аваагүй, сургуулиудад олгосон зарлагыг бүртгээгүй.	1	232,990.7	1	232,990.7			1	232,990.7
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан болон тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжийн гүйлгээг хөтөлбөр, зориулалтыг хооронд шилжүүлэн зарцуулсан.	1	21,219.8			1	21,219.8	1	21,219.8
Дүн	7	327,646.2	1	232,990.7	6	94,655.5	6	327,646.2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		мянган төгрөгөөр Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны болон тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжийн төлөвлөлтийг сайжруулах	1	-					1	-
Ажиллагсад олгох хоолны үнийн хөнгөлөлтийг олгохдоо 1 өдөрт	1	-					1	-

Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

тооцож олгох дүнг тогтоолгүйгээр ялгавартай дүнгээр олгосон.									
БШУС-ын 2022 оны А/125 дугаар тушаалаар батлагдсан жишигт нийцүүлж орон тоог аймгийн Засаг даргаар батлуулаагүй	1	-						1	-
Шалгуур хангаагүй ажилтанд тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжийг олгосон	3	71,107.8					3	71,107.8	
Хөвсгөл судлал 2022 эрдэм шинжилгээний хурлыг хариуцаж, зохион байгуулсан ажилтан нь тээврийн зардлыг өөрийн дансаар дамжуулж, олгосон.	1	4,240.0					1	4,240.0	
Бага боловсролын мэргэжилтэн Ундрахад докторын хөтөлбөрийн сургалтын төлбөрийн дэмжлэгийг олгосон.	1	1,600.0					1	1,600.0	
Батлагдсан НХМ шаардах хуудасгүйгээр шатахуун олгосон, зорчигчийн тийзгүйгээр замын зардал багш нарт олгосон.	2	16,167.5					2	16,167.5	
ХААН банкинд байрших төлбөрийн картын данс нээж, тэтгэмжийг дамжуулан олгосон болон орлого төвлөрүүлсэн	1	11,874.9					1	11,874.9	
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг давхардуулан олгосон	1	4,498.4	1	4,498.4					
БШУГ-ын дарга Ц.Ганзориг аймгийн Засаг даргын шийдвэргүйгээр үр дүнгийн урамшуулал авсан	1	2,070.4	1	2,070.4					
Томилолтыг олгохдоо томилолтоор ажиллах удирдамж, томилолтоор ажилласан илтгэх хуудас байхгүй, томилолтоор ажилласан огноо хоорондоо давхцсан, томилолт олгосон өдрөөс хойш 12 сарын 27-ны өдрийг хүртэлх өдрөөр томилолтын хуудас бичсэн, аймгийн төвийн сургуулиудад ажиллахад томилолтын хуудас бичсэн зэргээр хуурамчаар томилолтын хуудсыг үйлдэн олгосон	1	6,816.0	1	6,816.0					
Улаанбаатар, бусад аймаг хотод ажилласан томилолтын зардлыг үйл ажиллагаа зохион байгуулсан байгууллагаас олгосон байхад давхардуулан олгосон	1	917.6	1	917.6					
17 ажилтанд томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон	1	745.5	1	745.5					
Төрд ажилласан жилийг илүү тооцоолон тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжийг олгосон	1	5,461.3	1	5,461.3					
Мэргэжилтэн Н.Далайжаргал, жолооч Д.Бат-Оргил нарт томилолтын удирдамж, илтгэх хуудас, томилолтын хуудасгүйгээр томилолт олгосон	1	144.0	1	144.0					
Дүн	18	125,643.4	7	20,653.2	8	104,990.2	3	0.00	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Албан шаардлага		Үүнээс Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил:						
Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй	1	2,751,282.9			1	2,751,282.9
Дүн	1	2,751,282.9			1	2,751,282.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил:						
Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй	1	-	1	-		
Няравын тайланг сар бүр бэлтгэдэггүй, үлдэгдлийг нягтлан бодогч тулган баталгаажуулдаггүй, жолоочийн тооцоо бодоогүй	1	-	1	-		
Байгууллагын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлийг үр дүнтэй зохион байгуулаагүй	1	-	1	-		
Дүн	3		3	-		
Нийт дүн	4	2,751,282.9	3	-	1	2,751,282.9



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 27 өдөр

№ 32/АХЛ260439/ХПА-2023/20
/НА-СТА-ТШЗ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын албан хаагчийн докторын сургалтын төлбөр 1,600,000 (нэг сая зургаан зуун мянга)-н төгрөгийг төсвөөс төлж, хууль журманд заагдаагүй зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,” заалтыг хэрэгжүүлээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журам”-ын 4.2.1.6-т “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ц.Ганзориг, нягтлан бодогч Г.Батхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 27 өдөр

№ 41/ААЭБСОНЗ9/ХАА-2023/20
/НАА-СТА-ТЦЗ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн сайдын тушаалаар батлагдсан анхан шатны маягт шаардах хуудасгүйгээр 13,206,543 (арван гурван сая хоёр зуун зургаан мянга таван зуун дөчин гурав)-н төгрөгийн шатахуун, сургалтад оролцсон багш нарт зорчигчийн тийзгүйгээр 2,961,000 (хоёр сая есөн зуун жаран нэгэн мянга)-н төгрөгийн замын зардал, нийт 16,167,543 (арван зургаан сая нэг зуун жаран долоон мянга таван зуун дөчин гурав)-н төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны "Маягт, заавар батлах тухай" 347 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил гүйлгээний анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр гүйлгээг хийж бүртгэх, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ц.Ганзориг, нягтлан бодогч Г.Батхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНИМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 27 өдөр

№ 35/А.2022.01.139/ХӨА-2022/20
/НА - СТА - ТЦБ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж авах шалгуурыг хангаагүй ажилтанд 18,319,200 (арван найман сая гурван зуун арван есөн мянга хоёр зуу)-н төгрөг, тэтгэвэр тогтоолгоогүй нас барсан 2 багшийн ар гэрт нь 52,788,600 (тавин хоёр сая долоон зуун наян найман мянга зургаан зуу)-н төгрөг, нийт 71,107,800 (далан нэгэн сая нэг зуун долоон мянга найман зуу)-н төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 1.1 "Төрийн албаны тухай хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 60.1-д заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход энэ журмыг мөрдөнө.", 1.2 "Эрүүл мэндийн болон боловсролын салбарын хуульд заасан шалгуур, нөхцөлд хамаарах төрийн үйлчилгээний албан хаагч болон төрийн тусгай албан хаагчаас бусад энэ журмын үйлчлэлд хамаарах төрийн албан хаагч нийтдээ 5 жил, үүнээс сүүлийн 3 жил төрийн албанд тасралтгүй ажилласан тохиолдолд нэг удаагийн буцалтгүй тусламж авах эрх үүснэ." заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг хууль тогтоомжид заасан шалгуур хангасан албан хаагчид олгох;

2. Цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ц.Ганзориг, нягтлан бодогч Г.Батхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЯМ



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 07 өдөр

№ 36/20230439/ХАА-2023/АД
/11А - 17А - ТЛЦБ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХААН банканд зөвшөөрөлгүй данс нээж 11,874,900 (арван нэгэн сая найман зуун далан дөрвөн мянга есөн зуу)-н төгрөгийн орлогыг төвлөрүүлэн жилийн эцэст үлдэгдэлтэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ." заалтыг хэрэгжүүлээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. ХААН банкин дахь дансны үлдэгдлийг Хөвсгөл аймгийн төрийн сангийн 100170015403 тоот дансанд төвлөрүүлж, зөвшөөрөлгүй нээсэн дансыг хааж биелэлтийг 2023 оны 3 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ц.Ганзориг, нягтлан бодогч Г.Батхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 27 өдөр

№ 31/АДЭБ0439/КА-2023/20
/НА-СТА-ТШЗ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Хөвсгөл судлал 2022” эрдэм шинжилгээний бага хуралд оролцсон эрдэмтдийг Улаанбаатар хотоос тээвэрлэж ирэх, буцах зардал 4,240,000 (дөрвөн сая хоёр зуун дөчин мянга)-н төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу төлбөр гүйцэтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно” гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Ажил гүйлгээний анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр гүйлгээг хийж бүртгэх, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн БШУГ-ын дарга Ц.Ганзориг, нягтлан бодогч Г.Батхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 27 өдөр

№ 33/АХЭБД/139/ХӨА-2023/20
/11А-17А-ТНЗ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хуульд тогтоосон хугацаанд зохион байгуулаагүй, нярвын тайланг сар бүр бэлтгэж, үлдэгдлийг нягтлан бодогч баталгаажуулаагүй, жолоочийн тооцоо бодоогүй, байгууллагын дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 “эд хөрөнгийн дотоод тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журам”-ын 4.2.1.1-т “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”, 4.2.1.2 “хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баталгаажуулаагүй, баримтжуулаагүй” гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Нярвын тайланг сар бүр бэлтгэн, нягтлан бодогч үлдэгдлийг тулган баталгаажуулж хэвших, жолоочийн тооцоог сар бүр бодож, баталгаажуулах, хуульд заасан хугацаанд тооллогыг зохион байгуулж, үр дүнг тооцон нягтлан бодох бүртгэлд тусгах, байгууллагын дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулах, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043

2. Цаашид гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ц.Ганзориг, нягтлан бодогч Г.Батхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ





ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 02 сарын 27 өдөр

№ 26/2022/0439/ХА-2022/
20/НА-ЦТА-ТЧЗ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 4,498,368 (дөрвөн сая дөрвөн зуун ерэн найман мянга гурван зуун жаран найм)-н төгрөгийг Галт сумын ерөнхий боловсролын сургуулийн багш С.Жавзандуламд давхардуулан олгосон.
2. Байгууллагын нэр бүхий 17 ажилтны томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтөд 745,500 (долоон зуун дөчин таван мянга таван зуу)-н төгрөгийг давхардуулан олгосон.
3. Төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг олгохдоо төрд ажилласан жилийг илүү тооцоолж Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн багш Л.Эрдэнэчимэг 1,527,129 (Нэг сая таван зуун хорин долоон мянга нэг зуун хорин ес)-н төгрөг, Галт сумын цэцэрлэгийн нягтлан бодогч С.Нарантуяад 2,393,028 (хоёр сая гурван зуун ерэн гурван мянга хорин найм)-н төгрөг, Их-Уул сумын цэцэрлэгийн жижүүр Д.Даваадоржид 1,541,139 (нэг сая таван зуун дөчин нэгэн мянга нэг зуун гучин ес)-н төгрөг, нийт 5,461,296 (таван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга хоёр зуун ерэн зургаан) төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх;”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;” заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, “нийцсэн болон зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.5 “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Давхардуулан болон илүү олгосон 10,705,164 (арван сая долоон зуун таван мянга нэг зуун жаран дөрвөн) төгрөгийг Хөвсгөл аймгийн Төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ц.Ганзориг, нягтлан бодогч Г.Батхүү нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 08 сарын 27 өдөр

№ 27/АЭЭБ0439/ХӨА-2023/
20/НА-ТА-ТНЗ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын дарга Ц.Ганзориг нь эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2,070,408 (хоёр сая далан мянга дөрвөн зуун найм)-н төгрөгийн үр дүнгийн урамшуулал авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно.”, 1.2.1 “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид,” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрх бүхий удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр авсан үр дүнгийн урамшууллын 2,070,408 (хоёр сая далан мянга дөрвөн зуун найм)-н төгрөгийг Хөвсгөл аймгийн Төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ц.Ганзориг, нягтлан бодогч Г.Батхүү нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 08 сарын 27 өдөр

№ 25/А2210129/ХДА - 2023/
30/НА-СТА - ТШЗ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтаар нотлогдохгүй 6,960,000 (зургаан сая есөн зуун жаран мянга)-н төгрөгийн томилолтын гүйлгээг хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;” заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Анхан шатны баримтгүйгээр олгосон 6,960,000 (зургаан сая есөн зуун жаран мянга)-н төгрөгийг Хөвсгөл аймгийн Төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ц.Ганзориг, нягтлан бодогч Г.Батхүү нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
АХЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЫМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 02 сарын 27 өдөр

№ 24/АХДБД439/ХӨА-2023/00
1/1А-СТА-ТНБ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улаанбаатар болон бусад аймаг хотод зохион байгуулсан сургалт, арга хэмжээний зардлыг зохион байгуулагч талаас санхүүжүүлсэн байхад 917,600 (есөн зуун арван долоон мянга зургаан зуу)-н төгрөгийн томилолтын зардлыг давхардуулан олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 “Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн болон зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5 “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн”, 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн

ТОГТООХ нь:

1. Давхардуулан олгосон томилолт 917,600 (есөн зуун арван долоон мянга зургаан зуу)-н төгрөгийг Хөвсгөл аймгийн Төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ц.Ганзориг, нягтлан бодогч Г.Батхүү нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР:

Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043